



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/170

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Бугат багийн жижиг гудамжны үлдэгдэл санхүүжилтийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Г.Цэдэнбал - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Б.Түмэндэлгэр - Бугат багийн Засаг дарга

Ц.Цолмонбаатар - Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга


Д.Энхсүх - “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. “Шинэ төгс шийдэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

8400 01 0325
Zah A/170 Kh